



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

᠒᠐᠒᠒ оны ᠐᠑ сарын ᠐᠗ өдөр

Дугаар ᠑/561

Алтай хот

Комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, 37 дугаар зүйлийн 37.1.6 дахь заалт, Засгийн газрын 2021 оны “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм шинэчлэн батлах тухай” 212 дугаар тогтоол, Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны “Барилга байгууламжийн төвөгшлийн ангиллыг зориулалт, хүчин чадлаар нь тогтоох дүрэм батлах тухай” 211, 2020 оны “Зөвлөмж батлах тухай” 229 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Бигэр сумын нутаг дэвсгэрт баригдсан ТӨБЗГ-209/XII.1.1.252 дугаар гэрээт 100 ортой дотуур байрны барилгыг хүлээн авч, ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга: Д.Алтанзагас (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Гишүүдэд: М.Мандаххүү (аймгийн Засаг даргын Тамгын газрын Архивын тасгийн дарга)
Н.Долгорсүрэн (Барилгын хөгжлийн төвийн барилга байгууламжийн захиалагчийн хяналтын инженер)
Ц.Амарсанаа (Онцгой байдлын газрын гал түймрийн улсын хяналтын байцаагч, хошууч)
Д.Отгонжаргал (Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
Б.Батбилэг (Мэргэжлийн хяналтын газрын барилгын техникийн хяналтын улсын байцаагч)
Н.Пүрэвдулам (Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн барилгын асуудал хариуцсан мэргэжилтэн)
Х.Мөнхбаяр (Бигэр сумын Засаг даргын Тамгын газрын Санхүү албаны дарга) (ашиглагч)
Т.Мэндсайхан (Бигэр сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал) (ашиглагч)

2.

Б.Балдорж	(Орон нутгийн өмчийн газрын өмчийн бүртгэл хяналт хариуцсан мэргэжилтэн)
Д.Цэвэлмаа	(“Мэдээлэл холбооны сүлжээ” ТӨХК-ийн ерөнхий инженер)
Б.Бээжин	(“Алтай-Улиастайн эрчим хүчний систем” ТӨХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн дэд захирал бөгөөд ерөнхий инженер)
А.Нарандэлгэр	(“Барилга байгууламж” ХХК-ийн захирал) (зохиогч)
Н.Алтанхуяг	(“Ашид гэгээн өргөө” ХХК-ийн гүйцэтгэх захирал) (гүйцэтгэгч)
Нарийн бичгийн дарга: Б.Бямбадорж	(Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга бөгөөд аймгийн Ерөнхий архитектор)

2.Барилга угсралтын ажлыг байнгын ашиглалтад оруулахдаа гэрээнд тусгагдсан техникийн нөхцөл, зураг төсөл, холбогдох баримт бичгийн бүрдлийг хүлээн авч, үр дүнг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны дотор танилцуулахыг комисс (Д.Алтанзагас)-т үүрэг болгосугай.

3.Орон нутгийн өмчид бий болсон хөрөнгийг бүртгэж, цаашдын ашиглалт, арчилгаа, хамгаалалтад хяналт тавьж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Л.Ганхуяг)-т, Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар), Бигэр сумын Засаг даргын Тамгын газар (Ж.Жаргалсайхан), Бигэр сумын ерөнхий боловсролын сургууль (Т.Мэндсайхан)-д тус тус даалгасугай.

